



# БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

---

ТАТВАРЫН ЦОГЦ ШИНЭЧЛЭЛ  
БОЛОН ТАТВАРЫН МАРГААН  
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ

2024 ОН

**ТАТВАРЫН ЦОГЦ  
ШИНЭЧЛЭЛ БОЛОН  
ТАТВАРЫН МАРГААН  
ШИЙДВЭРЛЭЛТИЙН  
ТАЛААРХ БОДЛОГЫН  
БАРИМТ БИЧИГ**



Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам)-ын Санхүүгийн Үйлчилгээний Хорооны дарга ноён Шаукат Тапиа болон Европын Худалдааны Танхим (ЕвроЧам)-ын Гадаадын шууд хөрөнгө оруулалтын ажлын хэсгийн дарга ноён Даниел Махони нарын удирдлаган дор энэхүү бодлогын баримт бичгийг боловсруулав.

Энэхүү нийтлэлийн бүх эрх АмЧам болон ЕвроЧам-д хамаарна.

Бодлогын баримт бичгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн дахин хэвлэхэд АмЧам болон ЕвроЧам-аас зөвшөөрөл авна.

# ХУРААНГУЙ ТОЙМ

Энэхүү баримт бичгийн гол зорилго нь Монгол Улсад гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-д саад учруулж буй татварын гол асуудлуудыг тоймлон харуулах, Монгол Улсын татварын орчинг хөрөнгө оруулагчдад таатай болгох Монгол Улсын татварын хууль тогтоомж болон практикт шинээр оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийг тодорхойлоход оршино.

Энэхүү бодлогын баримт бичиг нь ГШХО-ыг татахын тулд татварын зарим хууль тогтоомж, практикт нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай байгаа татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг бодитоор эдлэх, татварын маргаантай хэргүүдийн урьдчилгаа төлбөрийн шаардлагыг өөрчлөх, импортын ажил, үйлчилгээнд ногдуулж буй оршин суугч бусын НӨАТ-ийн хасах, гэрээний үнэ эсхүл ашгийн сууринд үндэслэн АМНАТ-ын ногдуулах, үнэ шилжилтийн хууль хэрэгжилтийг боловсронгуй болгох, Татварын албаны заавал дагаж мөрдөх Татварын зөвлөмж гаргах хэрэгжүүлэлтийн механизмыг сайжруулах, оршин суугч бус татвар төлөгчийн Монгол Улсаас олсон

орлогод ногдуулах албан татварын хэмжээг 20 хувиас 10 хувь болгон бууруулах, татварыг зардал хассан сууриас тооцдог болгон өөрчлөх, хувьцааны шууд бус шилжүүлгийн татварын дүрмийг тодорхой болгох зэрэг асуудлуудыг онцлон хамруулсан болно.

Эдгээр дурьдагдаж байгаа асуудлуудын ихэнх нь хөрөнгө оруулалтад ихээхэн саад болж байгаа одоогийн зарим хууль тогтоомж болон практикт нэмэлт өөрчлөлт оруулах, цаашлаад гол зорилго нь хөрөнгө оруулагчдад наад зах нь татварын гажуудалгүй орчин бүрдүүлэн Монголд шинээр хөрөнгө оруулалт хийхээс татгалзахад хүргэдэг татварын зарим асуудлын өнөөгийн нөхцөл байдлыг сайжруулах явдал юм.

Бодлого боловсруулагчид хөрөнгө оруулалтыг идэвхтэй дэмжих хүрээнд бусад улс орнуудтай өрсөлдөхүйц татварын орчныг (чөлөөлөлт/хөнгөлөлт гэх мэт) бий болгох болон/эсвэл Монгол Улсад оруулах хөрөнгө оруулалтад томоохон урамшуулал дэмжлэгүүдийг санал болгох зэрэг өөр бусад нэмэлт асуудлууд ч байна.

Энэхүү баримт бичгийн хоёрдугаар хэсэгт татварын маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн байдлыг тодорхойлж, татварын маргаан шийдвэрлэхэд тулгамдаж буй сорилтууд болон Монгол Улсад татварын маргаан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох зарим зөвлөмжийг тусгасан болно.

# ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын татварын тогтолцоо нь 20 гаруй төрлийн татвараас бүрддэг. Монгол Улсын Их Хурал 2019 онд эдийн засаг, бизнесийг дэмжих зорилгоор татварын салбарт томоохон хууль тогтоомжийн шинэчлэл хийж, татварын гол хуулиудын шинэчилсэн найруулгыг баталснаар олон улсын татварын үзэл баримтлал, ойлголтуудыг нэвтрүүлсэн. Шинэчилсэн хуулиуд 2020 оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн<sup>1</sup>. Гэсэн хэдий ч Монгол Улсад ГШХО-ыг татах, дэмжихийн тулд татварын иж бүрэн шинэчлэл хийх шаардлагатай гэж АмЧам Монгол болон ЕвроЧам Монгол үзэж байна.

## Монгол Улсын голлох татварууд:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ);
- Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ);
- Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ).

## Бусад татвар:

- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
- Гаалийн татвар
- Онцгой албан татвар
- Тэмдэгтийн хураамж
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
- Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн хураамж
- Газрын төлбөр
- Агаарын бохирдлын төлбөр
- Нийслэл хотын албан татвар

ХХОАТ-аас гадна бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллагатай хөдөлмөрийн гэрээ, ажил, үйлчилгээний гэрээгээр ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй иргэн нийгмийн даатгалын шимтгэлийг заавал төлдөг. Цаашилбал, компанийн эрхэлж буй үйл ажиллагаа, хөрөнгөөс хамааран бусад татвар (АМНАТ, гаалийн албан татвар, авто тээврийн хэрэгслийн албан татвар, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар гэх мэт) ногдуулдаг. Монгол Улс 2017 оны 12 дугаар сард Татварын

суурийг багасгаж, ашиг шилжүүлэхийн эсрэг ЭЗХАХБ-ын (BEPS) санаачлагад нэгдэн орсон. Цаашлаад татварын цогц шинэчлэлдээ BEPS санаачлагын зарим зөвлөмжүүд болох татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм, үнэ шилжилтийн нарийн зохицуулалтууд, үйл ажиллагааны удирдлагыг гадаадаас хэрэгжүүлдэг аж ахуйн нэгжийн дүрэм зэрэг бусад олон улсын татварын дүрмүүдийг тусгасан болно. 2020 оноос эхлэн Татварын хяналт

<sup>1</sup> <https://investmongolia.gov.mn/taxation/>

шалгалтыг компанийг татан буулгах, НӨАТ-ын буцаан олголтыг баталгаажуулах зэрэг татварын зайлшгүй хяналт шалгалтад хамрагдах зарим тохиолдлуудаас гадна эрсдэлийн үнэлгээний шалгуурт үндэслэн хийж байна. Татварыг нөхөн ногдуулах, торгууль, алданги оногдуулах, татварын хөнгөлөлт эдлэх, алдагдал шилжүүлэх, НӨАТ-ыг баталгаажуулах хуулийн хөөн хэлэлцэх хугацаа 4 жил байна.

АНУ-ын Элчин сайдын яамны 2023 оны Хөрөнгө оруулалтын орчны тайланд “Засгийн газар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад татварын ижил хөнгөлөлт үзүүлэхээс гадна импортын түлш, хүнсний бүтээгдэхүүн эсхүл хөдөө аж ахуй, эрчим хүч зэрэг зорилтот салбарын импортын татвараас зарим тохиолдолд чөлөөлдөг. Монгол Улсын импортын 5 хувийн татвар, 10 хувийн нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-д хөнгөлөлт үзүүлж болно. Засгийн газар уламжлалт болон ногоон эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтад тухайлбал нэмэлт тариф, цахилгааны үнийн хөнгөлөлт, татварын хөнгөлөлт зэрэг урамшууллыг санал болгож болно.

Мөн Засгийн газар ашигт малтмал, хөдөө аж ахуй, дэд бүтэц зэрэг салбар дахь хөрөнгө оруулалтад татварын хөнгөлөлтийг тухайн тохиолдол бүрээр өргөтгөн олгож болно. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу Монгол Улсад зохих ёсоор бүртгүүлж, татвараа төлж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд 27 хүртэлх жилийн хугацаанд татварыг тогтворжуулах зэрэг таатай нөхцлүүдийн хамт хөрөнгө оруулалтыг дэмжих багц хөтөлбөрт хамрагдах боломжтой. Засгийн газар онолын хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалттай төсөлд баталгаа гаргах эсхүл хамтран санхүүжүүлэх боломжтой ч практикт үүнийг хийх нь ховор” гэв<sup>2</sup>.

Гадны хөрөнгө оруулагчид ногдуулсан татварын хэмжээ тийм өндөр биш ч нэгдсэн байдлаар авч үзэхэд асуудал үүсгэж байна. Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд ААНОАТ-ын 10 хувь,

НӨАТ-ын 10 хувь, суутгалын албан татварын 20 хувь буюу нийт 40 хувийн татвар төлөх үүрэгтэй.

2017 оноос хойш Монгол Улсад Татварын шинэчлэлийн талаар өргөн хүрээнд яригдсан. Ингэснээр ТЕХ, ААНОАТ-ын тухай хууль, ХХОАТ-ын тухай хууль, НӨАТ-ын тухай хууль зэрэг татварын голлох хуулиудыг Засгийн газраас хэрэгжүүлж буй татварын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Их Хурал /хууль тогтоох байгууллага/ нилээдгүй шинэчлэн найруулсан. Татварын эдгээр шинэ хуулиуд нь Засгийн газар, Сангийн яам, Монгол Улсын Татварын албанаас эдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм журмуудыг гаргахыг шаардаж байгаа. Татварын шинэ хууль тогтоомжууд нь 2020 оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.

---

<sup>2</sup> <https://mn.usembassy.gov/2023-investment-climate-statement-mongolia/#:~:text=EXECUTIVE%20SUMMARY,stakeholders%20during%20rulemaking%20warrant%20caution.>

# ТАТВАРЫН БОЛОН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СОРИЛТУУД БА ЗӨВЛӨМЖҮҮД

Татварын багц хуулиудад зайлшгүй шаардлагатай эрх зүйн шинэчлэлийн талаар АмЧам, ЕвроЧам хамтран дараах саналуудыг дэвшүүлж байна. Улс орныхоо эдийн засгийг хөгжүүлж, олон мянган ажлын байр бий болгож, татвар төлж, улс орныхоо хөгжилд ухамсартайгаар хувь нэмрээ оруулж буй дотоод, гадаадын хөрөнгө оруулалттай олон зуун бизнес эрхлэгчдийнхээ нэрийн өмнөөс бидний хүсэлтийг хүлээн авахыг Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас хүсч байна.

Татварын хууль тогтоомжид холбогдох дараахь эрх зүйн нэмэлт, өөрчлөлт оруулахыг санал болгож байна. Үүнд:

1

## **Хөрөнгө оруулалтын хууль: Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон Татварын тотворжуулалтыг эдлэх боломж олгох**

Хөрөнгө оруулалтын тухай одоогийн хуулинд татварын урамшуулал, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхээр тусгагдсан байдаг хэдий ч практик дээр бодитоор хэрэгждэггүй. Тиймээс гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд Татварын хуулиудын зохицол, хамаарлыг уялдуулан нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай байна (тухайлбал, хөрөнгө оруулагчдад нэмэлт, таатай урамшууллыг санал болгох)

Татварын болон хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийн хөрөнгө оруулалтын гэрээний татварын тогтворжуулалтын үндсэн ойлголтын цар хүрээ, давуу талын тухай зүйл заалтуудыг тодорхой болгох нэн шаардлагатай байна. Энэхүү ойлголтын зөрүүтэй байр суурь, тайлбараас болж гэрээлэгч талууд хоорондоо 400 сая орчим долларын татварын маргаантай байна.

2

## **Татварын маргаантай зөрчилд тулд урьдчилгаа төлбөр төлөхийг шаарддаг**

Одоогийн ТЭХ-иар маргаантай байгаа татварын хэргүүдийн шүүхийн эцсийн шийдвэрийг үл харгалзан ТЭГ урьдчилсан байдлаар татварын акты татварын төлбөрийг татвар төлөгчөөр бүрэн төлүүлж байна. ТЭХ-ийн 47 дугаар зүйлийн 47.3-т зааснаар татвар төлөгч нь Татварын маргаан таслах зөвлөлд гомдоллон маргаанаа хянан шийдвэрлүүлэх зорилгоор маргаантай татварын үнийн дүнгийн 10 хувийг урьдчилан байршуулах ба түүний дээд хэмжээ нь 100 сая төгрөг байхаар тогтоогдсон. Энэ нь татвар төлөгчид шударга бус хандаж байгаа ба мөн ихээхэн хэмжээний санхүүгийн дарамтыг учруулж байна. Татварын алба татварын маргаанд шүүх дээр ялагдах тохиолдлууд байдаг, тиймээс ТЭХ -ийн 43.3 зүйл заалтыг хүчингүй болгох шаардлагатай байна.

**3****Импортын ажил, үйлчилгээнд ногдуулж буй НӨАТ-ыг хасдаг болох**

Импортолж буй ажил, үйлчилгээнд ногдуулж буй НӨАТ нь бизнесийн өртгийг нэмэгдүүлж, ашгийг бууруулан оюуны хөрөнгө оруулалтыг хаан боогдуулж байна. Импортолж буй ажил, үйлчилгээ нь голдуу гадаадын мэргэжилтэнгүүдийн ажил мэргэжлийн мэдлэг, ур чадвар, туршлагыг импортлосон мэргэжлийн үйлчилгээнд хамааралтай байдаг. Тиймээс импортын ажил, үйлчилгээнд ногдуулж буй оршин суугч бусын НӨАТ-ыг хасагдуулдаг болох хуулийн өөрчлөлт хийх нь зүйтэй.

**4****АМНАТ-ын төлбөр нь Гэрээний үнэ эсхүл Ашигт суурилсан байвал зохистой**

Өнөөгийн АМНАТ нь СЯ-ны зохицуулалтаар зарлагдсан зах зээлийн үнэд үндэслэж буй нь бизнес эрхлэгчдэд татварын өндөр дарамт үүсгэн, хөрөнгө оруулагчдыг хөрөнгө оруулахаас дайжуулах шалтгаан болж байна. Тиймээс үүнийг Гэрээний бодит үнэ эсхүл Ашигт суурилсан байдлаар өөрчилвөл зохистой хэмээн үзэж байна.

**5****Үнэ шилжилтийн дүрэм журмын хэрэгжилтийг сайжруулах**

ҮШ дүрэм журамд зах зээлийн үнийг жишиглэн тогтоох мэдээллийн эх сурвалжийг заагаагүй байдаг. Мөн ҮШ -ийн татварын хяналт шалгалтын үед татвар төлөгчдөд ҮШ-ийн залруулгыг хэрхэн тооцсон, процесс нь хэрхэн зохих журмын дагуу үйлдэгдсэн талаар ил тодоор баримтжуулан харуулах хэрэгтэй байна. Татварын алба нь ҮШ шалгалтын зорилгоор эрх бүхий гадны байгууллагатай харилцан солилцсон мэдээллээ нээлттэй байдлаар хуулийн хүрээнд хуваалцах нь зохистой байна.

**6****Хувьцааны борлуулалтад ногдуулах татвар**

Одоогийн татварын хууль тогтоомжоор Монгол компанийн хувьцааг оршин суугч бус этгээд борлуулсны нийт орлогод ногдуулдаг 20 хувийн татварыг олсон орлогын цэвэр дүнд нь ногдуулахаар өөрчлөх санал байна (энэ асуудлаар өнгөрсөн онд зөвхөн МХБ-д нээлттэй арилждаг хувьцаатай холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч бусад компанийн хувьд хамааралгүй байгаа).

Олон улсын татварын дүрмийн дагуу хувьцаа борлуулсны орлогын цэвэр дүнд татвар ногдуулдаг буюу энэ нь хөрөнгө оруулагчийн оруулсан хөрөнгө оруулалтыг хасч тооцон татварын суурийг тодорхойлдог. Түүнчлэн, энэхүү одоогийн зохицуулалтаар энэхүү татварыг оршин суугч татвар төлөгчийн хувьд цэвэр дүнд, харин оршин суугч этгээдийн хувьд нийт дүнд татвар ногдуулж буйг татварын ялгаварлан гадуурхалт гэж үзэж болохоор байна.

**7****Оршин суугч бус татвар төлөгчид ногдуулж буй үйлчилгээний орлогын суутган татвар**

Одоогийн хуулиар Монгол компанийн оршин суугч бус үйлчилгээ үзүүлэгчид төлж байгаа Монголоос эх үүсвэртэй орлогод татвар ногдуулдаг (Монголын тал нийт үнийн дүнгийн 20%-иар татварыг ногдуулан суутган авдаг).

Практик дээр энэхүү татварыг оршин суугч татвар төлөгч бус Монгол компани төлдөг ба учир нь оршин суугч бус гадаад компани нь Монголтой хамааралтай татварыг Монголд компанид үүрэгжүүлэн үйлчилгээний төлбөрийг татвар оролцуулсан дүнгээр өсгөн харуулахыг шаарддаг. Энэ нь үндсэндээ Монгол талын татвар төлөгчийг татваржуулсан, тэдэнд учруулж буй зардал юм.

**8****ТЕГ-ын заавал дагаж мөрдөх Татварын зөвлөмж гаргадаг хэрэгжилтийн механизмыг сайжруулах**

Татварын албанаас татварын тодорхойгүй асуудал дээр зөвлөмж гаргах эрх болон үүгээрээ татвар төлөгчид үйлчлэх үүргийг сайтар сануулах, идэвхжүүлэх хэрэгтэй байна. Өнөөгийн байдлаар хууль хэрэгжилтийн гурван татварын зөвлөмж гаргасан байгаа ба татварын хуулийн нилээдгүй зөрүүтэй тайлбар, тодорхойгүй асуудлууд байгаа нь зөвлөмжүүдийг олноор гаргах шаардлагатай харуулж байна.

Гэсэн хэдий ч уг дүрэм нь татварын давхардал, тодорхой бус байдал, татварын албаны зөрүүтэй тайлбар зэрэг асуудлуудыг араасаа дагуулж, практикт нилээдгүй хүндрэл учруулж байна. Тухайлбал, газар, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эрхтэй компанийн хувьцааг борлуулсан ажил гүйлгээнд нийт дүнгийн 20%-аар, эсхүл цэвэр дүнгийн 10%-аар татвар ногдуулах уу, татвар ногдуулах суурийг хэрхэн тодорхойлох, давхар татварыг хэрхэн арилгах зэрэг олон асуудал тодорхой бус байна. Тухайлбал, Татварын албаны зарим албан хаагчид оршин суугч бус татвар төлөгч Монгол Улсын уул уурхайн компанийн хувьцааг борлуулсан тохиолдолд хувьцаа борлуулагч болон Монголын уул уурхайн компанийн аль аль нь Монгол Улсад татвар төлөх ёстой гэж тайлбарлаж байгаа. Ингэснээр Монголын компани нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээний дүнгээс ААНОАТ-ын 10%, оршин суугч бус борлуулагч нь хувьцааны борлуулалтын орлогын нийт дүнгээс 20%-аар суутган татвар төлнө гэж үзэж байна.

**9****Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эрх шилжүүлэх, борлуулах**

2020 оноос эхлэн ААНОАТ-ын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу шууд бусаар эрх шилжүүлсний татварын дүрэм мөрдөгдөж эхэлсэн. Уг дүрэм нь Монгол компаниудын газар болон ашигт малтмалын эрхийг эзэмшин, түүнийгээ шууд/шууд бусаар шилжүүлж буй ажил гүйлгээнд мөрдөгдөхөөр байгаа.

Цаашилбал ААНОАТ-ын тухай хуулийн 30 дугаар зүйлийг дагаж мөрдөхгүй байх нь тухайн эрхийг цуцлахад хүргэж болох тул бизнес эрхлэгчдэд ихээхэн хохирол учруулж болзошгүй юм. Тиймээс тодорхойгүй байдлыг арилгахын тулд ААНОАТ-ын тухай хуулийн 30 дугаар зүйлийг эргэн харж, засах нь зүйтэй. Энэхүү сайжруулалтыг хийхгүй бол Монгол улсын хөрөнгө оруулалтын орчин ихээхэн хүндрэл сорилтуудтай тулгарах, тухайлбал уул уурхайн төслүүдэд, ялангуяа хайгуулын болон хөрөнгө босгох хугацааны үе шатанд яваа төслүүдэд ихээхэн муугаар нөлөөлж болзошгүй юм.



---

# ТАТВАРЫН МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

---

## ШҮҮХИЙН ӨМНӨХ МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ

Монгол Улсад 2020 он хүртэл Татварын маргаан таслах зөвлөл нь Нийслэлийн маргаан таслах зөвлөл (эсвэл НМТЗ) болон Татварын ерөнхий газрын (ТЕГ) дэргэдэх Маргаан таслах зөвлөл (ТЕГ МТЗ) гэсэн хоёр үе шаттайгаар үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд ТЕГ дэргэдэх МТЗ нь дээд шатны байгууллага ба түүний шийдвэр нь татварын бүх шатны байгууллагын эцсийн шийдвэр юм<sup>3</sup>.

### ӨМНӨ НЬ МӨРДӨГДӨЖ БАЙСАН ДАВЖ ЗААЛДАХ ПРОЦЕССИЙН ҮЕ ШАТУУД

- Харьяалах татварын алба (гомдол гаргасан татвар төлөгчийн) нь дүүргийн татварын алба, нийслэлийн татварын алба бол НМТЗ-д татвар төлөгч нь гомдол гаргана.
- НМТЗ-аас гаргасан шийдвэрийг татвар төлөгч эс зөвшөөрвөл ТЕГ МТЗ-д гомдол гаргах эрхтэй бөгөөд түүний шийдвэр нь шүүхийн өмнөх шатны эцсийн шийдвэр болно.

Гэсэн хэдий ч 2020 оны Татварын ерөнхий хуулийн шинэчлэлийн дагуу хоёр шатны МТЗ -өөр дамжин гомдоллох журмыг хөнгөвчилж, шүүхийн өмнөх маргааныг шийдвэрлэх шаардлагын дагуу татварын маргааныг хянан шийдвэрлэх ганцхан шатлалтай болсон. Шинэ журмын дагуу МТЗ хэргийг түдгэлзүүлэх шийдвэр гаргаж, тодорхой нөхцөл хангагдсан тохиолдолд хэргийг дахин шалгахыг ТЕГ даалгаж болно. Ийм давтан шалгалтыг дээд шатны татварын байгууллага хийх бөгөөд хугацаа нь 3 сараас илүүгүй байна. Нөхөн ногдуулалтын акт шинээр гарсан тохиолдолд анхны нөхөн ногдуулалтын актыг хүчингүй болгоно.

Татвар төлөгч маргааныг шийдвэрлэхийн тулд нөхөн ногдуулсан татварын 10 хувьтай тэнцэхүйц урьдчилгаа татвар төлөх шаардлагатай бөгөөд энэ нь 100 сая төгрөгөөр хязгаарлагдана.

Дараахь графикт Монгол Улсад одоогийн байдлаар татварын маргааныг хянан шийдвэрлэж буй ерөнхий үйл явцыг харуулав.

---

<sup>3</sup>EY's tax alert "Mongolia reforms its key tax legislation" (June 4, 2019)

# ТАТВАРЫН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ ЯВЦ


ТМЗ нь дахин тооцсон татварын хэмжээш бууруулахад тоцооллын алдаа гарсан эсвэл ТМЗ-ийн зүгээс маргааныг шийдвэрлэхэд татварын үйл ажиллагаанд тодорхой бус байдал гарсан гэж үзвэл хэргийг түдгэлзүүлж, хяналтын татварын албанд шилжүүлж болно.

“Тооцооллын алдаа” гэдэг нь татварын акт тавихад гаргадаг тоцооллын алдааг хэлнэ.

### 3 сар түдгэлзүүлэх:

ТЕГ ТАТВАРЫН акт хянаж, холбогдох өөрчлөлтийг хийнэ.

Өөрчлөлт ороогүй тохиолдолд ТМЗ хэргийн үргэлжлүүлэн хэлэлцэнэ.



- Түдгэлзүүлэх
- Дахин шалгасны дараа татвар болон торгуулийн хэмжээ өөрчлөх
- Хүчингүй болгох
- Батлах

1. Шүүхийн хуулийг хэрэгжүүлэхэд гардаг зөрүүтэй байдлыг арилгах
2. Зохих ёсны үйл ажиллагааг зөрчил шүүхийн шийдвэрт нөлөөлдөг.
3. Уг хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн байдаг
4. Хуулийн хэрэглээний эрх зүйн шинэ үзэл баримтлалыг бий болгох нь нэн чухал

## **ТАТВАР ТӨЛӨХ ХУГАЦААГ СУНГАХ**

Татвар төлөгчид татвар төлөх хугацааг сунгах хүсэлт гаргаж болох ба ТЕГ нь хоёр жил хүртэлх хугацааг сунгах боломжтой. Сунгах тохиолдолд барьцаа эсвэл баталгааны зохицуулалт шаардлагатай байж болно.

## **ТАТВАР ХУРААЛТ БА АЛБАДАН ХЭРЭГЖҮҮЛЭХ**

Татварын өрийг эрсдэлтэй гэж үзвэл татвар төлөгчөөс татварын өрийг нэн даруй гаргуулж авна. ТЕГ нь эдгээр татварыг татвар төлөгчөөс тусгай журмаар хураан авах үйл ажиллагааг эхлүүлэх эрхтэй.

- Татвар төлөгчийн эд хөрөнгийг хурааж, дуудлага худалдаагаар бэлэн мөнгөөр захиран зарцуулах замаар татварын өр барагдуулахыг ТЕГ-т зөвшөөрдөг. ТЕГ нь банкны дансыг царцааж, банкуудад татварын өр барагдуулах төлбөр шилжүүлэхийг зааварчилж болно. Татвар төлөгч нь гуравдагч этгээдээс төлөх татварын үлдэгдэл болон авлагатай тохиолдолд татвар төлөгчийн нэрийн өмнөөс татвар төлөхийг гуравдагч этгээдэд даалгаж болно. Татвар хураалтыг албадан хэрэгжүүлэхийн тулд ТЕГ-т хууль эрх зүйн янз бүрийн журам, процесс байдаг.
- ТЕГ татварын өрийг төлөх анхны сануулга болгон татвар төлөгчийн автомашинд хязгаарлалт тавьж болно. Мөн татварын өрийн хэмжээ 20 сая төгрөгөөс дээш, татварын өрийг барагдуулах хөрөнгөгүй бол татвар төлөгч (гадны иргэн)-д хориг тавихаар ТЕГ цагаачлалын албанд хүсэлт гаргаж болно.

## **ТАТВАРЫН ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ ТОХИОЛДОЛД ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ**

Татварын үүргээ биелүүлээгүй, эсхүл суутган татварыг аваагүй зэрэг татварын хууль хэрэгжүүлээгүй зөрчлийн тохиолдолд 30-50 хувийн торгууль ногдуулдаг.

